



**“СОНО ФИНТЕК ББСБ”
ХХК –ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

АГУУЛГА

- ✓ **БИДНИЙ ТУХАЙ**
- ✓ **ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО**
- ✓ **ОНЦЛОХ АЖЛУУД**
- ✓ **ОНЦЛОХ КОНТЕНТ**
- ✓ **ББСБ-ЫН САЛБАРЫН ТОЙМ**
- ✓ **ФИНТЕК ҮЗҮҮЛЭЛТ**
- ✓ **ЭРСДЛИЙН УДИРДЛАГА**
- ✓ **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ**
- ✓ **БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ**

БИДНИЙ ТУХАЙ

Эрхэм зорилго

БҮТЭЭМЖИЙГ ДЭМЖСЭН МОНГОЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ ЗЭЭЛИЙН АПП БОЛНО.
/Харилцагчийн санхүүгийн хэрэглээг хурд, хүртээмж, технологийн дэвшил, процесс, ухаалаг шийдлээр хангана./

Үнэт зүйлс

СОНС

Зүрх сэтгэлээ сонс. Амжилтын дуудлагыг сонс.

ОЛ

Амжилтыг ол. Ялагдвал сургамж ол.

НЭЭ

Өөрийн болон бусдын боломжийг нээ.

ОРОЛЦ

Өөрөөсөө илүү гар.

Банк бус санхүүгийн зах зээлийн шинэ эрин болох технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу финтек үйлчилгээний анхдагчийн нэг байж харилцагч, хамтран ажиллагч байгууллагууддаа хялбар, хурдан шуурхай, зардал бага үйлчилгээг Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт хүртээмжтэйгээр хүргэн ажиллаж байна.

Уриа үг

МОНГОЛЧУУДЫН САНХҮҮГИЙН СУУРЬ ХЭРЭГЛЭЭ БОЛНО.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

2024 онд бид орчин үеийн ухаалаг платформуудыг ашиглан өдөр тутмын үйл ажиллагаагаа автоматжуулж, алба хэлтэс, ажилчдын харилцаа холбоог хялбаршуулахад тэмүүлж ажилласан.



TIMELY цаг бүртгэлийн ухаалаг аппликейшныг нэвтрүүлснээр уламжлалт системийг халж, байгууллагад эерэг соёлыг бүрдүүлэх, ажилтан ажил олгогч хоорондын харилцааг үр дүнтэй, илүү эерэг болгосон.



ХЭНИЙГ

ажил горилогчийн хэн бэ гэдэгт төвлөрөх

ХААНА

ажилтныг ажлын байранд тохироцыг үзэх

ХЭДЭЭР

ажилтанд тохирох цалин хөлсийг олох

Бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт дээр “ЗХ” –ийн дүрмийг” баримтлан илүү мэргэжлийн боловсон хүчин хайх дээр төвлөрч ажилласан

Бид олон ургалч, ялгаатай байдлыг хүндэлж, шашин шүтлэг, үндэс угсаа, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран сонгон шалгаруулалтаа эн тэнцүү явуулж, харилцан бие биеэ хүндэтгэн харьцаж, ажилтан бүрийн саналыг хүлээн авч нээлттэй оролцоог дэмжин ажилласан.

ОНЦЛОХ АЖЛУУД

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

"Соно финтек ББСБ" ХХК нь СЗХорооноос Итгэлцлийн болон Цахим төлбөр тооцоо, Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлийг тус тус авлаа.

UB MARATHON 2024

Дэлхийн улс үндэстнүүдийн нас хүйс, үндэс угсаа, үзэл баримтлал үл хамааран жилдээ нэг удаа хамтдаа өөрийгөө ялж, эрүүл мэндээ хамгаалах бүх нийтийн баярын өдөр буюу 2024 оны Улаанбаатар марафоны Ерөнхий ивээн тэтгэгчээр ажилласан. Энэхүү өдөр бид брэндийн нэр хүндээ өсгөх бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниулах ажлуудыг зохион байгуулж гүйцэтгэсэн.

ОЙН БАЯР

2024 оны эхний хагаст "СОНО ФИНТЕК"-н 5 жилийн ойн баяр тохиосон бөгөөд төрсөн өдөртөө зориулан нийт харилцагчдаа 250 SONO POINT олгож мөн сэтгэл ханамжийн судалдаа апп-р өгсөн харилцагчдад нэмж 250 SONO POINT олгосон. Нийт судалгаанд 31,430 хүн хамрагдсан бөгөөд цуглуулсан датандаа үндэслэн ирээдүйд хийж гүйцэтгэх ажлуудаа тодорхойлсон. Мөн ажилчдынхаа дунд "METACOG" тоглоомын аргаар дотоод ажилтнуудын ур чадварын үнэлгээ хийх зэргээр амжилттай ашиглаж эхэлсэн.

MIRA ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

2024 оны 04-р сарын 15-нд "Соно Финтек ББСБ" ХХК нь байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг MIRA агентлагаар BBB- (Хөрөнгө оруулалтын зэрэглэл) үнэлгээтэйгээр тогтоолгов. Ингэснээр тус зээлжих зэрэглэлийг ашиглан 50 тэрбум төгрөг хүртэлх бондыг гаргах боломжтой боллоо.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

Хугацаа хэтэрсэн зээлтэй ажиллах баг болон системийг амжилттай зохион байгуулж багцад эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх онд 2.05% байснаас 3-р улирлын байдлаар 1.21% болгон бууруулсан. Энэ нь 2024 оны салбарын дунджаас 5 дахин бага үзүүлэлт юм.



МӨРӨӨДЛИЙН ТӨГӨЛ

"СОНО ФИНТЕК ББСБ" ХХК нь 2024 онд ТӨВ аймгийн эрдэнэ суманд байрлах "Мөрөөдлийн төгөл" ойжуулах төсөлд 3 дахь жилдээ оролцон ирээдүй хойч үеийнхээ төлөө 750 ширхэг мод суулгаж гар бие оролцлоо.



90'000 ГАРУЙ ХҮНД ХҮЧИЛ ТӨРӨГЧ БЭЛЭГЛЭЛЭЭ

Дэлхий дахинд цаг тутамд 273'600 ширхэг модыг устгаж цаас үйлдвэрлэдэг. Энэ нь цаасны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр ой мод устаж үгүй болох, улмаар цаасны хаягдал нэмэгдэж байгаа нь харамсалтай. "1 мод 4 хүний амьдралынх нь туршид амьсгалах агаарыг бий болгох чадвартай" Иймээс бид экологийн тэнцвэрт байдлыг хангах, ирээдүй үр хойчдоо ногоон ирээдүйг бий болгохоор зорилт тавин ажиллаж байна.

ОНЦЛОХ КОНТЕНТ

2024.07.31-2024.08.15

Соно апп хэрэглэгчдийн худалдан авалтын зээл авах хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор Тримон студитэй хамтран зураг авалт, 2D анимейшн хосолсон 81 секундын брэнд видео хийж гүйцэтгэсэн.

URGOD CINEMA
IMAX

2024.11.22-12.22

Өргөө 3 IMAX болон Дархан хотын Өргөө 6 кино театруудад нийт 1,400 суудалтай 9 танхимд бүх үзвэрийн өмнөх зар сурталчилгаанд байршиж байна.

ТЕЛЕВИЗ

2024.11.22-12.06

Нийт 5 телевизээр брэнд видеоны сурталчилгааг 15 хоногийн хугацаатай цацсан бөгөөд NTV телевиз нь 2025.01.02 хүртэл цацагдана.

Reach – **1,100,000**
Reaction – **3,600**
Share – **219**
Comment - **115**

Цацсан TV сувгууд




Intv



CENTRAL

MOVIE BOX

Цацсан youtube сувгууд



ФИНТЕК ҮЗҮҮЛЭЛТ/СОНО ФИНТЕК/


Нийт Appstore таталтын тоо

482,454.00

Нийт Playstore таталтын тоо

187,042.00

Нийт апп таталт /Сар бүрээр мянга/



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

"СОНО ФИНТЕК ББСБ" ХХК нь 2024 онд мэдээллийн технологийн үйл ажиллагаа, технологийн төлөвлөлт, сайжруулалтыг уялдуулан, дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэхийн зэрэгцээ харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, санхүүгийн үйлчилгээг тасалдалгүй хүргэхийн тулд техник болон системүүдийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангахад голлон анхаарал хандуулж ажиллав.

2024 онд мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт **ISO 27001** стандартын магадлан аудитад тэнцэж амжилттай баталгаажууллаа.

Дотоод сүлжээ, мэдээллийн урсгалд хийсэн технологийн шинэчлэлт

Мэдээллийн системийн болон дэд бүтцийн сүлжээний найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, дотоод ба гадаад сүлжээн дэх кибер аюулгүй байдлын эмзэг байдал, нөөц холболтыг хэрэгжүүлэх замаар бизнесийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах ажлын гүйцэтгэлийн төлөвлөлт гаргаж, төслийг хэрэгжүүлэн олон улсын стандартын дагуу сайжруулалт хийх зорилгоор гадаад болон дотоод өгөгдлийн урсгалыг ангилан тусгаарласан.

Мөн мэдээллийн аюулгүй байдлын хангах, харилцагчийн мэдээлэл алдагдах мэдээллийн урсгалыг хянах үүднээс гадаад сүлжээний орчны сайжруулалтын хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Системийн тасралтгүй байдал

Системийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах нь бидний гол зорилт бөгөөд үүний хүрээнд тогтмол сайжруулалтуудыг хийдэг. Тайлант оны сайжруулалтуудын үр дүнд үндсэн системүүдийн тасалдлыг бүрэн хянаж ажилласан бөгөөд системийн унасан нөхцөлд автоматаар өөрийгөө сэргээх шийдлийг амжилттайгаар нэвтрүүлэн ажиллаад байна. Түүнчлэн үндсэн системийн Олон улсын **TIER-III** стандартыг хангасан Дата төвд байршдаг бөгөөд тайлант онд системийн багтаамжийг 2 дахин хурдыг 3 дахин нэмэгдүүлж ажилласан.



CERTIFICATE

This is to certify that the Information Security Management System of

SONO Fintech NBFILLC

13th and 14th Floor, Twin Tower – 2, Seoul Street, 5th Khoroolol, 2nd Khoroo,
Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongol

has been assessed and found to conform to the requirements of

ISO/IEC 27001:2013

This Certificate is valid for the following scope

Information Security Management System applies to SONO Fintech
NBFILLC's Fintech Credit Service and Factoring Service.

SOA, Version 2.0; Dated: 05/12/2022

Certificate No.	:AMER15914
Initial Registration Date	:17/12/2022
Registration Date	:27/01/2024
Issue Date	:31/01/2024
Expiry Date	:16/12/2024
Recertification Date	:16/12/2025



Bharve
Director

AMERICO QUALITY STANDARDS REGISTECH PVT. LTD

Key Location: 1910 Thomes Ave, Cheyenne, Wyoming, WY 82001, USA
Operations Office: D 303, 104 Nisarg plaza, Bhumkar chowk - Hinjewadi road, Wakad, Pune 411057

INVESTMENT RATING **BBB-**

"Соно Финтек ББСБ" ХХК нь байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийн "BBB-" зэрэглэл бүхий хөрөнгө оруулалтын үнэлгээгээ "MONGOLIAN INVESTMENT RATING AGENCY"-р 2024 оны 04-р сарын 15-нд тогтоолголоо.

ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Дотоод хяналт

"Соно финтек ББСБ" ХХК нь бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааны процесст учирч болох эрсдэлийг тогтмол бүртгэж, үр нөлөө болон түүнийг бууруулах төлөвлөгөөг гаргадаг. Үүнийг Дотоод хяналтын хэлтсээр дамжуулан холбогдох журам, баримт бичиг, техник хангамжийн тусламжтайгаар мөрдөж, хэрэгжүүлж ажилладаг.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, үйл ажиллагаанаас гарч болох хууль зүйн эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, аргачлалуудыг үйлчилгээндээ нийцүүлж, дотоод бодлого, журмын зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, сургалт зохион байгуулан шаардлагатай асуудлаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, зөвлөмж авч ажиллалаа.

Чанаргүй зээлийг түвшинг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хүрээнд оновчтой систем, багийг ажиллуулах загварыг боловсруулсан. Үүний үр дүнгээр чанаргүй зээлийг үе шаттайгаар бууруулах зорилт тавин ажилласан ба тухайн хугацаанд төлөвлөсөн ажлуудыг үр дүнтэйгээр амжилттай хийж гүйцэтгээд байна. Чанаргүй зээлийн бууруулах, барагдуулах процессыг сайжруулах, авч хэрэгжүүлсэн тухайлсан арга хэмжээнүүдийн үр дүнд чанаргүй зээлийг тогтвортой боломжит бага түвшинд барьж ажиллалаа. Цаашид энэхүү загварыг илүү боловсронгуй болгож хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын бүрэлдэхүүнд:

Ажилтан

Байгууллагын бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлд хяналт хийх.

Нэгжийн удирдлага

Нэгжүүд эрсдэлээ хэрхэн удирдаж байгааг хяналт тавих, компанийн хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, тайлагнах, төлөвлөгөө гаргах үүрэгтэй.

Гүйцэтгэх удирдлага

Шийдвэр гаргах, хяналт тавих.

БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ

"Соно финтек ББСБ" ХХК-аас үзүүлдэг "Sono mongolia" финтек зээлийн үйлчилгээний нөлөөллөөр Хэрэглэгчид банк, санхүүгийн байгууллагуудын урт дараалалд зогсолгүй барьцаагүйгээр зээлийн үйлчилгээг авахад боломжийг бүрдүүлсэн. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх хэрээр цаг хугацаа, шаардлагагүй зардал болон хог хаягдал буурч, бүх талуудын сэтгэл ханамж өсөж байна.

Харилцагчийн зээлийн судалгаанд шаардлагатай олон төрлийн бичиг баримтыг дижитал хэлбэрээр цуглуулан харилцагчид финтек зээлийн үйлчилгээг үзүүлснээрээ байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөөлөлийг Соно финтек ББСБ 2 төрлөөр үзүүлж ажилласан байна.

Бид харилцагчиддаа 24/7 буюу бүхий л цаг үед санхүүгийн асуудлаа шидэхэд бэлэн бөгөөд харилцагч монгол улсын өнцөг булан бүрээс "Sono mongolia" аппликейшнээр дамжуулан финтек үйлчилгээг авах боломжтой.

Зөвхөн 2024 онд төрийн үйлчилгээгээр дамжуулан манай харилцагчид:

Зөвхөн 2024 онд Соно финтек ББСБ-ын хувьд:



Гэхдээ ерөнхийдөө, дунджаар бензин моторын машин нь 1 литр бензинийг шатаахад ойролцоогоор 2.3 кг нүүрстөрөгчийн давхар исэл (CO2) ялгаруулдаг. Тэгвэл харилцагч зээлийн үйлчилгээг авахдаа 1,500см.куб мотортой машинаар 15 минут хугацаагаар зарцуулж банкны салбар нэгжид хүрдэг гэж үзвэл бид ойролцоогоор харилцагчийн замдаа зарцуулах **62,437,125** минутад ялгаруулах нүүрс хүчлийн хийн хэмжээ **19,147.4 тонн** ялгаруулах нүүрс хүчлийн хийн хэмжээг бууруулж чадсан байна.